

ХҮНДЭТ ПРОФЕССОР ЦОЛ ОЛГОВ

ШУА-ийн Олон улс судлалын хүрэлэнгийн эрдмийн зөвлөлийн 2007 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрээр улс төр судлаач, нийтлэлч Б.Батбаяр (Баабар)-т Олон улс судлалын хүрээлэнгийн “Хүндэт профессор” цол олгосон байна. Эрдмийн зөвлөлийн тогтоолд дурьдахдаа түүний туурвисан олон бүтээл, тэр дундаа “ХХ зууны Монгол, нүүдэл суудал, олз гарз” зохиол нь ХХ зууны Монголын түүх бичлэгийн талаар нэлээд олон шинэлэг санааг дэвшүүлсэн, түүнчлэн Монголын гадаад харилцааны түүх, гадаад бодлого судлалын ажилд тодорхой хэмжээгээр дэвшил болсон гэж үнэлсэн байна.

Тухайн үед нийтлэлч Баабар гадаад оронд томилолтоор ажиллаж байсан тул өнгөрсөн 7 дугаар сарын 20-ны өдөр Олон улс судлалын хүрээлэнгийн байранд хүрэлцэн ирж цол, гэрчилгээгээ гардан авсан бөгөөд өөрийн туурвисан номнынхоо англи хэл дээрх хоёр дахь хэвлэлийн дээжээс хүрээлэнгийн номын санд дурсгаж, судлаач эрдэмтэдтэй санал бодлоо солилцсон байна.

*Мэдээ бэлтгэсэн Д.Золбоо (ОУСХ-ийн
эрдэм шинжилгээний ажилтан, магистр)*